



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020.07.30 № 03

Асуулт тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 284 дүгээр тогтоолоор Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг 4 эгнээ бүхий хатуу хучилттай авто зам болгон өргөтгөн, шинэчлэх шийдвэр гарсан.

Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган Хөвсгөл, Төв аймаг зэрэг аж үйлдвэр, газар тариалан, мал аж ахуй, аялал жуучлалын гол бүс нутгийг холбодог уг авто замыг ашиглалтанд хүлээлгэн өгөх ажил удааширсны улмаас түр замаар зорчиж буй иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч, тухайн бүс нутгийн байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын төлөвлөгөө, явцын талаар;

2. Авто замын эвдрэл, түр замаар зорчсоноос үүдэн хохирсон иргэдийн гомдлыг хэрхэн шийвэрлэж буй талаар;

3. Тус авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил дуусах хүртэлх хугацаанд түр замаар зорчиж буй иргэдийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах талаар;

4. "Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам" төслийн хэрэгжилтийн явцын талаар.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хувийг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ч.УНДРАМ

0000000031